



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН  
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ  
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

ДИЗАЙН ЗУРАГ ЗҮЙ, ТЕХНОЛОГИ

УЛААНБААТАР 2021



БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН  
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ  
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

# ЗӨВЛӨМЖ

ДИЗАЙН ЗУРАГ ЗҮЙ, ТЕХНОЛОГИ

*АНХНЫ ХЭВЛЭЛ*



## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

---

Суралцагчийн үнэлгээ ..... 2

## БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

---

Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэглэх арга зүйн зөвлөмж..... 5

Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар .....11

✓ Даалгавар боловсруулах арга зүй, зөвлөмж .....11

✓ Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар .....13

Гурав. Үнэлгээний даалгаварт шинжилгээ хийх, багшлахуйд  
дэмжлэг үзүүлэх арга зүй .....20

✓ Даалгаварт шинжилгээ хийх аргачлал.....20

## СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго<sup>1</sup>/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх<sup>2</sup>/, үнэлж дүгнэх<sup>3</sup> зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-т суурилсан байна.

### ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

<sup>1</sup> Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

<sup>2</sup> Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

<sup>3</sup> Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад<sup>4</sup> нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



<sup>4</sup> Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.





## Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэглэх арга зүйн зөвлөмж

### ✓ **Үнэлгээний шалгуур боловсруулсан арга зүй:**

Зөвлөмжийн энэхүү хэсэгт Бүрэн дунд боловсролын түвшинд Дизайн зураг зүй, технологи хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсруулсан аргачлалыг харуулж, үнэлгээний шалгуурыг хэрэглэх арга зүйн зөвлөмжийг XI ангийн “Хувцасны технологи” үнэлгээний нэгж агуулгын жишээгээр тайлбарлав.

Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурын бүтцийн тухай “Суурь бүрэн дунд боловсролын хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”-ын 19 дүгээр хуудаснаас танилцаарай.


### ✓ **Үнэлгээний нэгж**

Ямар агуулгын хүрээнд үнэлэх вэ?

Сургалтын хөтөлбөрүүдийн суралцахуйн зорилтуудыг багцалсан илэрхийлэл;

Дизайн зураг зүй, технологи хичээлийн үнэлгээний нэгжийг сургалтын хөтөлбөрийн агуулгын тогтолцоогоор (бүлэг) сонгосон болно. Сургалтын хөтөлбөрийн агуулга үнэлгээний нэгжийг зураг 1-ээр харуулав.

Зураг 1. Үнэлгээний нэгж тодорхойлсон аргачлал (XI ангийн жишээгээр)



✓ **Суралцахуйн үр дүн**

Сурагч юуг сурсан байх вэ?

Суралцахуйн тодорхой үе шат (ээлжит болон нэгж хичээл, улирал боловсролын түвшин)-ыг дүүргэсний дараа сурагчийн эзэмших мэдлэг ойлголт, чадварыг тодорхойлсон илэрхийлэл;

Суралцахуйн үр дүнг анги тус бүрийн үнэлгээний нэгжид хамаарах агуулгын хамгийн чухал концепцийн мэдлэг, эзэмших чадварыг багтаан тодорхойлсон. Суралцахуйн үр дүнг тодорхойлсон аргачлалыг Хүснэгт 1-ээр харуулав.

**Хүснэгт 1. Үнэлгээний нэгж агуулгын суралцахуйн үр дүнг тодорхойлсон аргачлал (XI анги “Хувцасны технологи” нэгжийн жишээгээр)**

№	Сургалтын хөтөлбөрийн агуулга, суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүн
1	<p>11.2.1а. Монгол хувцасны үүсэл хөгжил, төрөл ангилал, онцлог, бэлгэдлийг жишээгээр үзүүлж тайлбарлах</p> <p>11.2.1б. Үндэсний загвартай орчин үеийн хувцасны загварын шинэ санаа шийдлийг гол объектийн арга ашиглан зохиомжлон бүтээх</p> <p>11.2.1в. Байгалийн гаралтай ба хиймэл торгыг физик, хими, механик, технологийн шинж чанараар нь харьцуулах</p> <p>11.2.1г. Монгол дээл хувцас эсгэх уламжлалт арга технологийг хэрэглэн эсгүүр байгуулах</p> <p>11.2.1д. Үндэсний загвартай хувцсыг орчин үеийн эсгүүр, загварчилгааны аргаар эсгэх, загварчлах</p>	Хувцасны технологи	ДЗЗТ11.2.1 ҮД5. Үндэсний загвартай орчин үеийн хувцасны суурь үлгэрийг байгуулж, загварчилж чаддаг болно.
2	<p>11.2.1е. Монгол хувцас эсгэх, оёх технологи дарааллыг загварын онцлогт тохируулан төлөвлөх</p> <p>11.2.1ж. Монгол үндэсний хувцсыг уламжлалт ба орчин үеийн арга технологийг хослуулан эсгэх, оёх, чимэглэх</p>		ДЗЗТ11.2.1 ҮД6. Үндэсний загвартай орчин үеийн хувцсыг технологи дарааллын дагуу эсгэж, оёж чаддаг болно.


Дизайн зураг зүй, технологи сургалтын хөтөлбөрийн агуулгын бүлэг тус бүрийг нэгж агуулга хэмээн үзэж үнэлгээний нэгжийг, суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхүйц хүрэхийг хүсэж буй үр дүнгээр суралцахуйн үр дүнгээ тодорхойлсон. Иймд суралцахуйн үр дүнгээр нэгж хичээлийг төлөвлөх боломжтой.

Зураг 2. Нэгж хичээлийн санаа (XI ангийн жишээгээр)



Үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүнгээс анги хоорондын болон тухайн ангийн агуулгын залгамж холбоо, өргөсөл, гүнзгийрэл тодорхой харагдана. Нэгжийн агуулгын суралцахуйн үр дүнг Зураг 3-аар харьцуулж харуулав.

Зураг 3. Агуулгын залгамж холбоо (Бүрэн дунд боловсролын түвшин “Хувцасны технологи” X-XII анги)




✓ **Суралцахуйн үр дүнгийн шалгуур**

Сурсан эсэхийг яаж мэдэх вэ?

Сурагч тухайн суралцахуйн үр дүнд хүрсэн эсэхийг илрүүлэх бөгөөд багш нарт сурагчийн амжилт/ гүйцэтгэлийн талаар дүгнэлт хийх боломжийг олгох хэмжүүр;

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуурыг тодорхойлсон аргачлалыг XI ангийн “Хувцасны технологи” нэгжийн жишээн дээр Зураг 4 – өөр харуулав.

Зураг 4. Үнэлгээний нэгж тус бүрээр хүрэх суралцахуйн үр дүнгийн шалгуур (XI анги “Хувцасны технологи” нэгжийн жишээгээр)



**Кодын тайлбар:** ДЗЗТ11.2.1.ҮД6.Ш6

(ДЗЗТ) Дизайн зураг зүй, технологийн, (11) 11 дугаар анги, (2.1) бүлэг/ай, (ҮД6) суралцахуйн үр дүн 6, (Ш6) суралцахуйн үр дүнгийн шалгуур 6 гэж ойлгоно.

**✓ Гүйцэтгэлийн түвшин**

Ямар түвшинд эзэмшсэн бэ?

Суралцахуйн үр дүнгийн шалгуурыг ямар түвшинд эзэмшсэнийг тодорхойлох илэрхийлэл;

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуурын гүйцэтгэлийн хүрэх 4 түвшинг тодорхойлсон аргачлалыг “Хувцасны технологи” нэгжийн жишээн дээр харуулав.

**Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур:** ДТ11.2.1.ҮД5.Ш2. Мөртэй хувцасны суурь үлгэрийг үндэсний хэв маяг, хэлбэрт оруулан өөрчилж загварчилдаг.

**I түвшин.** Хувцасны загварын онцлогт тохирсон загварчилгааны аргыг сонгодог.

**II түвшин.** Мөртэй хувцасны бүрдэл хэсгүүдийг үндэсний хэв маяг, загварт оруулан өөрчилж загварчилдаг.

**III түвшин.** Сонгосон загварын онцлогт нийцүүлэн мөртэй хувцсыг үндэсний хэв маяг, загварт оруулан өөрчилж загварчилдаг.

**IV түвшин.** Сонгосон загварт нийцсэн шинэ үлгэрийг зохион бүтээдэг.

Суралцахуйн үр дүн тус бүрийн үнэлгээний шалгуур, шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн 4 түвшинг анги бүрээр боловсруулсныг “Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”-ын шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин хэсгээс хараарай.

## ✓ Үнэлгээний арга зүй:

Үнэлгээний талаарх ойлголтыг олон янзаар тодорхойлсон байдаг. Тухайлбал, “...аливаа зүйлийн мөн чанар, үнэ цэнийг тодорхойлох үйл явц” (OCED), “Үнэлгээ нь хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг хянуу, системтэйгээр эргэж харах хандлага” (SIDA)...чанарын тухай мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх, тайлагнах үе шатуудыг агуулсан цаашдын бодлого, хэрэгжилтийг тодорхойлох систем бүхий эрэл хайгуул” (World Bank) гэж тодорхойлсон байдаг бол манай боловсролын салбарын үнэлгээний бодлогын баримт бичгүүдэд “Сурагчдын сурах үйл ажиллагааг мэдээлэх, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх үйл явц”-ыг үнэлгээ хэмээнэ гэсэн ойлголтод санал нийлж хэрэгжүүлж байна.

Зураг 5. Үнэлгээний төрөл, хэлбэр



## ✓ Оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээнд үнэлгээний шалгуурыг хэрэглэх арга зүй

Үнэлгээний нэгж агуулгын гараа, явц, үр дүнг тодорхойлоход үнэлгээний шалгуурыг хэрэглэнэ.

**Оношлох үнэлгээ:** Сурагчид юу мэддэг, чаддаг, юу мэдэхгүй, чадахгүй, ямар ойлголт, төсөөлөл, хандлагатай байна вэ? гэдгийг илрүүлэх зорилгоор хичээлийн жил, хагас жил, улирал, бүлэг сэдэв эхлэхийн өмнө оношлох үнэлгээ хийдэг. Оношлох үнэлгээ хийснээр тухайн анги, сурагчийн ялгаатай байдлыг харгалзан агуулгыг бататгах арга зүйг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх суурь мэдээлэлтэй болно. Оношлох үнэлгээний үр дүнг сурагчийн сурлагын амжилт, ахиц, өөрчлөлтийг тооцоход хэрэглэнэ. Жишээ нь: 10 дугаар ангийн хичээлийн жилийн эхэнд эсвэл сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө сурагчийн мэдлэг, чадварын түвшинг тандах зорилготой 9 дүгээр ангийн хичээл, сургалтыг үнэлэх шалгуураар даалгавар боловсруулж оношилж болно. Суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшинд нийцүүлэн даалгавар боловсруулж оношлох үнэлгээг хийх боломжтой.

**Явцын үнэлгээ.** Багш ээлжит хичээл бүрээр суралцагчдын мэдлэг, чадвар хэрхэн эзэмшиж байгааг ажиглах, хянах зорилгоор явцын үнэлгээний хэлбэрээс тухайн хичээлд тохиромжтойг нь сонгон хэрэглэнэ. Явцын үнэлгээний нэг чухал хэсэг нь сурагчийг дан ганц багш үнэлэх биш, суралцагч өөрийгөө болон бусдыг үнэлэх асуудал юм. Багш, сурагчдыг өөрийгөө болон бусдыг үнэлэх төрөл бүрийн арга барилд сургах хэрэгтэй. Сурагч өөрийгөө болон бусдыг үнэлэхдээ суралцахуйн зорилго, зорилт, үнэлгээний шалгуураа ойлгож мэдэх ба өөрийн үйл ажиллагаанд шинжилгээ хийх чадвар эзэмшдэг.

Явцын үнэлгээний үр дүнд суралцагч “Би юуг мэдэж, чадаж байна вэ?, цаашид юуг бие дааж эсвэл багшийн тусламжтайгаар сурах ёстой вэ? Илүү сайн суралцах, амжилтаа ахиулахын тулд юуг анхаарах хэрэгтэй вэ?” гэдгээ ойлгож, мэддэг.

#### **Өөрийн үнэлгээний жишээ:**

*Үнэлгээний шалгуур.* Д33Т11.2.1ҮД5.Ш1.Монгол дээлний суурь үлгэрийг загварчилгааны аргуудаар өөрчилж загварчилдаг.

*II түвшин.* Монгол дээлний бүрдэл хэсгийг өөрчилж загварчилдаг.

#### **Хүснэгт 2. Сурагчийн өөрийн үнэлгээний жишээ**

БИ...	Сайн	Дунд зэрэг	Итгэлгүй
Монгол дээлний захны эсгүүрийг тойруу захтай болгож өөрчилж чадна.			
Монгол дээлний хормойг нугалаатай дэрэвгэр загвартай болгож өөрчилж чадна.			
Монгол дээлний ханцуйг залгаатай болгож өөрчилж чадна.			


Багш сурагчдын өөрийн үнэлгээний үр дүнд анализ хийж, ямар шалгуур, гүйцэтгэлийн түвшинд хангалтгүй байгааг илрүүлж, цаашид анхаарч хичээлийн арга зүй, төлөвлөлтдөө тусгаж ажиллах хэрэгтэй.

**Үр дүнгийн үнэлгээ:** Нэгж агуулга, бүлэг сэдвийн төгсгөлд үр дүнгийн үнэлгээ хийж болно. Нэгж агуулгын хүрэх үр дүн, үнэлгээний шалгуурт тулгуурласан цогц даалгаврыг боловсруулж сурагчдын мэдлэг, чадварыг үнэлж болно. Үр дүнгийн үнэлгээг хийхдээ үнэлгээний даалгаврыг суралцахуйн үр дүнгийн шалгуурын дагуу үнэлгээний нарийвчилсан төлөвлөгөө /блюпринт/-нд үндэслэн боловсруулна. Үүнийг 2 дугаар бүлэг “Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар” хэсгээс харна уу.

## Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар

### ✓ Даалгавар боловсруулах арга зүй, зөвлөмж

Зураг 6. Даалгавар боловсруулах аргачлал



#### ✓ Блюпринт боловсруулах аргачлал

Блюпринт нь даалгавар боловсруулах нарийвчилсан зураглал (матриц) юм. Өөрөөр хэлбэл, даалгаврын агуулга, дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан төлөвлөлт гэж ойлгож болно. Сурагчдаас тодорхой хугацаанд тодорхой агуулгыг багтаасан сэдвийн үр дүнг илрүүлэх шалгалтын даалгавар зохиоход блюпринтийг боловсруулна. Блюпринтийг чанартай боловсруулах нь маш чухал юм. Блюпринтийг боловсруулахад таксономийн мэдлэг шаардлагатай. Одоогоор Блумын таксономи (1956), Соло таксономи (1982)-ийг боловсролын зорилт, үнэлгээг тодорхойлоход түгээмэл хэрэглэж байгаа ба энэ талаарх судалгааны үр дүн багагүй байдаг. Иймээс багш нар таксономийн мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэх шаардлагатай юм. Үнэлгээний нэгж, нэгжийн суралцахуйн үр дүнг илрүүлэх шалгалтын агуулга боловсруулахад блюпринтийн дараах загварыг ашиглаж болох юм.

#### ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 5. ХУВЦАСНЫ ТЕХНОЛОГИ

11 дүгээр ангийн “Хувцасны технологи” агуулгын хүрээнд суралцахуйн үр дүнд хүрсэн эсэхийг илрүүлэх шалгууруудыг 9, 10-р ангидаа судалсан монгол дээл, баривч, даашинзны эсгүүр байгуулж, эсгэж, оёх мэдлэг ойлголт, чадвартай залгамж холбоотойгоор боловсруулсан. Үнэлгээний шалгуурууд нь үндэсний загвартай орчин үеийн хувцас зохион бүтээхтэй холбоотой мэдлэг ойлголт, гүйцэтгэх ур чадварыг үнэлэхэд чиглэгдсэн.

**Хүснэгт 3. Үнэлгээний бюопринтийн загвар (XI анги "Хувцасны технологи" нэгжийн жишээгээр)**

Суралцахуйн үр дүн	Үнэлгээний шалгуур	Гүйцэтгэлийн түвшин	Сонгох					Задгай					Нийт			
			Мэдлэг	Оноо	Чадвар	Оноо	Хэрэглээ	Оноо	Мэдлэг	Оноо	Чадвар	Оноо	Хэрэглээ	Оноо	Даалгаврын тоо	Оноо
ДЗЗТ11.2.1.ҮД5. Үндэсний загвартай орчин үеийн хувцасны суурь үлгэрийг байгуулж, загварчилж чаддаг болно.	ДЗЗТ11.2.1.ҮД5. Ш1. Монгол дээлний суурь үлгэрийг загварчилгааны аргуудаар өөрчилж загварчилдаг.	I	1	1										4	8	29%
		II						1	2							
		III								1	2					
		IV								1	3					
	ДЗЗТ11.2.1.ҮД5. Ш2. Мөртэй хувцасны суурь үлгэрийг үндэсний хэв маяг, хэлбэрт оруулан өөрчилж загварчилдаг.	I									1	2		4	9	32%
		II							1	2						
		III								1	2					
		IV								1	3					
ДЗЗТ11.2.1.ҮД6. Үндэсний загвартай орчин үеийн хувцсыг технологи дарааллын дагуу эсгэж, оёж чаддаг болно.	ДЗЗТ11.2.1.ҮД6. Ш3. Байгалийн гаралтай ба хиймэл торгыг физик, хими, механик, технологийн шинж чанараар нь харьцуулах замаар хэрэглээг тодорхойлдог.	I					1	4					4	11	39%	
		II						1	2							
		III									1	3				
		IV								1	2					
		I														
		II														
		III														
		IV														
Даалгаврын тоо			1					2	7		2		12			
Нийт оноо				1					6	16		5		28		
Эзлэх хувь			8	3				17	21	58	58	17	18		100%	

**✓ Даалгавар боловсруулах аргачлал**

Үнэлгээний зорилго, зорилтоос хамаарч даалгаврын төрөл хэлбэр харилцан адилгүй байдаг. Тэгэхдээ сонгох болон задгай даалгаврыг төрлийг даалгавар боловсруулахад түгээмэл хэрэглэдэг.

*Сонгох даалгавар* гэж хариултын хувилбаруудтай түүнээс зөв хариулыг сонгох хэлбэрээр боловсруулсан даалгаврыг хэлнэ. Хариултын хувилбар нь гурваас багагүй таваас ихгүй байх зохимжтой. Хариултын хувилбараас зөв хариулт зөвхөн нэг байна. Харин хариултын бусад хувилбар шалгуулагчид үнэмшил төрөхүйц байх хэдий ч, зайлшгүй буруу хариулт байна.

*Задгай даалгавар* нь танин мэдэхүйн дээд түвшний үр чадварыг үнэлэхэд чиглэсэн нээлтэй дэлгэрэнгүй хариулыг шаарддаг байна. Задгай хэлбэрийн даалгавар нь алхамчилсан бүтэцтэй байх бөгөөд хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн алхам бүр өөр өөр мэдлэг, чадварыг илрүүлэхээр



боловсруулагдсан байхаас гадна алхмууд нь хоорондоо хамааралтай цогц даалгавар байж болно. Цогц даалгавар нь дангаараа нэг бүлэг сэдвийн агуулгыг үнэлэхээс гадна хэд хэдэн агуулгын хүрээг хамарсан байхаар боловсруулагдсан байж болно. Задгай даалгаврыг боловсруулахад даалгаврын зорилго, шалгуур нь тодорхой байх ёстой. Задгай даалгаврыг нөхөх, богино буюу товч хариулттай, дэлгэрэнгүй хариулттай гэсэн гурван төрөлд хуваадаг байна. Дизайн зураг зүй, технологийн хичээл нь гүйцэтгэлд тулгуурлан зохион байгуулагддаг онцлогтой. Үүнтэй холбоотойгоор шалгалтын агуулга дахь даалгаврууд нь ихэнхдээ задгай хэлбэрээр боловсруулсан байдаг.

*Даалгавар боловсруулахад тавигдах ерөнхий шаардлага:*

- Даалгаврын тоо гүйцэтгэх хугацааг сурагчдын нас биеийн онцлогт тохируулан оновчтой тогтоох
- Танин мэдэхүйн үе шат, шалгуурт нийцүүлэн даалгаврыг боловсруулах
- Даалгаврын олон хэлбэрийг ашиглах
- Даалгаврын тохирц, найдвартай байх чанарыг хангах
- Сургалтын хөтөлбөрийн агуулгад үндэслэсэн, сурлагын амжилтыг илрүүлэхүйц байх
- Даалгаврын хариулт (түлхүү)-ийг хамт боловсруулах
- Даалгаврын агуулга салаа утгагүй байх
- Даалгавар нь үнэлгээний шалгуур, гүйцэтгэлийн түвшинд тулгуурлан боловсруулсан байх

Үнэлгээний шалгуурт нийцүүлэн “Хувцасны технологи” агуулгын хүрээнд боловсруулсан цогц даалгаврын жишээг авч үзье.

## ✓ Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар


*ДЗЗТ11.2.1.ҮД5. Үндэсний загвартай орчин үеийн хувцасны суурь үлгэрийг байгуулж, загварчилж чаддаг болно.*

**Үнэлгээний шалгуур:** ДЗЗТ11.2.1.ҮД5.Ш1. Монгол дээлний суурь үлгэрийг загварчилгааны аргуудаар өөрчилж загварчилдаг.

**I түвшин:** Хувцасны загварын онцлогт тохирсон загварчилгааны аргыг сонгодог.

### Даалгавар 1.


Дараах дан дээлний танаасны хэлбэр болон байрлалыг ажиглаад энгэрийн загварчилгаатай зөв харгалзуулна уу. (БСШУСЯ, 2019, Дизайн зураг зүй, технологи XI анги Хуудас 101-р дасгал)



**II түвшин:** Монгол дээлний бүрдэл хэсгийг (энгэр, зах, ханцуй, хормой) өөрчилж загварчилдаг.


### Даалгавар 2.

1.



Монгол дээлний захыг өндөр тойруу захтай болгож суурь үлгэр дээр өөрчилж загварчилаарай.

2.



Монгол дээлний хормойг зурагт өгөгдсөн загвараар суурь үлгэр дээр өөрчилж загварчилаарай.

**III түвшин.** Сонгосон загварын онцлогт нийцүүлэн монгол дээлийг өөрчилж загварчилдаг.

Даалгавар 3.



Загварын дээлний загварын тодорхойлолтыг бичиж, дээлний суурь үлгэрийг зурагт өгөгдсөнөөр загварчилаарай.

Загварын тодорхойлолт

.....

.....

**IV түвшин.** Сонгосон загварт нийцсэн шинэ үлгэрийг зохион бүтээдэг.


Даалгавар 4.

Х хэлбэртэй үндэсний загвартай орчин үеийн хувцасны бүрдэл хэсгүүдийг М1:4 хэмжээгээр тооцоолон бэлтгэж хяналтын тэмдэглэгээний цэг болон үндсэн утасны чиглэлийг сумаар тэмдэглээрэй

Үнэлгээний шалгуур: ДЗЗТ11.2.1.ҮД5. Ш2. Мөртэй хувцасны суурь үлгэрийг үндэсний хэв маяг, хэлбэрт оруулан өөрчилж загварчилдаг.

**I түвшин:** Хувцасны загварын онцлогт тохирсон загварчилгааны аргыг сонгодог.

Даалгавар 5. Дараах загварчилгаагаар хийгдэх ханцуйны загварын зургийг зурж харуулна уу.



**II түвшин:** Мөртэй хувцасны бүрдэл хэсгүүдийг үндэсний хэв маяг, загварт оруулан өөрчилж загварчилдаг.

Даалгавар 6.

1.



Мөртэй хувцасны энгэрийг зурагт өгөгдсөн загвараар өөрчилж загварчилаарай.

2.



Мөртэй хувцасны ханцуйг зурагт өгөгдсөн нударгатай загвараар суурь үлгэрийг өөрчилж загварчилаарай.

**III түвшин:** Сонгосон загварын онцлогт нийцүүлэн мөртэй хувцсыг үндэсний хэв маяг, загварт оруулан өөрчилж загварчилдаг.

**Даалгавар 7.**

Мөртэй хувцсыг А силуэт хэлбэртэй үндэсний загвартай орчин үеийн хувцасны загварт оруулан өөрчилж загварчилаарай.

*IV түвшин:* Сонгосон загварт нийцсэн шинэ үлгэрийг зохион бүтээдэг.

**Даалгавар 8.**

А хэлбэртэй үндэсний загвартай орчин үеийн хувцасны бүрдэл хэсгүүдийг М1:4 хэмжээгээр тооцоолон бэлтгэж хяналтын тэмдэглэгээний цэг болон үндсэн утасны чиглэлийг сумаар тэмдэглээрэй.

*ДЗЗТ11.2.1 ҮД6. Үндэсний загвартай орчин үеийн хувцсыг технологи дарааллын дагуу эсгэж, оёж чаддаг болно.*

**Үнэлгээний шалгуур:** ДЗЗТ11.2.1.ҮД6.ШЗ. Байгалийн гаралтай ба хиймэл торгыг физик, хими, механик, технологийн шинж чанараар нь харьцуулах замаар хэрэглээг тодорхойлдог.

*I түвшин:* Байгалийн гаралтай ба хиймэл торгыг физик, хими, механик, технологийн шинж чанараар нь харьцуулж, зураг, бүдүүвч ашиглан тайлбарладаг.

**Даалгавар 9.**

1. Байгалийн гаралтай болон хиймэл торгоны гарал үүслийг тодорхойлж бичээрэй.

Байгалийн .....

Химийн .....

2. Торгыг шинж чанараар нь харьцуулж тайлбарлаарай.

<i>Шинж чанар</i>	<i>Байгалийн</i>	<i>Хиймэл</i>
Физик шинж чанар		
Химийн шинж чанар		
Механик шинж чанар		
Технологийн шинж чанар		

*II түвшин:* Байгалийн гаралтай ба хиймэл торгыг гадаад байдал, (гялалзалт, үрчийлт, бат бөх) шатах шинж чанараар (шатах байдал, үнэр, үнс) нь туршиж ялгадаг.

**Даалгавар 10.**

1. Байгалийн ба хиймэл торгыг энгийн аргаар ялган таних үр дүнг бичнэ үү.

<i>Туршилт</i>	<i>Байгалийн</i>	<i>Хиймэл</i>
Гадаад байдал		
Шаталтын байдал		
Үнс		
Үнэр		

*III түвшин:* Байгалийн гаралтай ба хиймэл торгыг физик, хими, механик, технологийн шинж чанараар нь харьцуулах замаар хэрэглээг тодорхойлдог.

**Даалгавар 11.**

1. Даавууны шинж чанарыг харьцуулж хэрэглээг (хувцас, эд зүйлс) нэрлээрэй.

<i>Даавуу</i>	<i>Даавууны онцлог шинж чанар</i>	<i>Хэрэглээ</i>
Торго		
Хөвөн даавуу		

*IV түвшин:* Үндэсний загвартай орчин үеийн хувцасны зориулалт, загварын онцлогт нийцүүлэн материалыг сонгодог.

**Даалгавар 12.**

1. Үндэсний загвартай орчин үеийн хувцсанд тохирох 1 даавууг нэрлээд сонгосон шалтгаанаа бичээрэй.

Тохиромжтой даавуу .....

Сонгох болсон шалтгаан:

Давуу тал .....

Сул тал .....

2. Сонгосон 1 даавууны арчилгааны зааврын тайлбарыг бичээрэй.

Арчилгаа	Тэмдэглэгээ	Тайлбар
Угаах		
Индүүдэх		

**Үнэлгээний шалгуур.** Д33Т11.2.1.ҮД6. Ш4. Үндэсний загвартай орчин үеийн хувцсыг технологи дарааллын дагуу эсгэдэг.

**I түвшин:** Эдлэлийн урт, бүрдэл хэсгийг (загвар, хийц, даавууны өргөн, хээ) харьцуулан тодорхойлох аргаар даавууны орцыг тооцдог.

**Даалгавар 13.**

1. Даавууны орцыг ..... зэргийг тооцож тодорхойлдог.

- A. Эдлэлийн урт, бүрдэл хэсэг
- B. Эдлэлийн загвар, хийц, даавууны өргөн, хээ
- C. Эрүүл ахуй болон физик шинж чанар
- D. Эдлэлийн урт, ханцуйны урт

**II түвшин:** Даавууг (торго) дарааллын дагуу эсгүүрт бэлтгэдэг.

**Даалгавар 14.**

Даавууг эсгүүрт бэлтгэх дарааллыг зөв дугаарлана уу.

- ..... Даавууны үндсэн утасны чиглэлийг тодорхойлох
- ..... Даавуунд чийг дулааны ажиллагаа хийх
- ..... Даавууны өнгө, ар талыг тодорхойлох

**III түвшин:** Үлгэрийг материалын үндсэн утасны чиглэлийн дагуу байрлуулж, оёдлын хэмжээг тооцоолж тэмдэглэдэг.

**Даалгавар 15.**

Үлгэрийг даавуун дээр байрлуулах дарааллыг бичнэ үү.

- a) .....
- b) .....
- c) .....
- d) .....
- e) .....

**IV түвшин:** Сонгосон үндэсний загвартай орчин үеийн хувцасны бүрдэл хэсгүүдийг эсгэдэг.

**Даалгавар 16.**

1. Үндэсний загвартай орчин үеийн хувцасны үлгэрийг материал дээр эсгэх аргыг зурж үзүүлнэ үү.


А. Материалыг нугалсан байдал	Б. Нугалсан материал дээр үлгэрийг байрлуулсан байдал

Үнэлгээний шалгуур. ДЗЗТ11.2.1.ҮД6.Ш5. Үндэсний загвартай орчин үеийн хувцсыг загварын онцлогт нийцүүлэн эмждэг.

*I түвшин:* Загварын онцлогт тохируулан эмжих хэсэг болон эмжээрийг бэлтгэдэг.

**Даалгавар 17.**

1. Хээтэй хээгүй 2 төрлийн материал дээр эмжээр бэлтгэх зүсэлтийг зурж харуулна уу.




2. Өнгө материал дээр эмжээрийг суулгаж оёх өргөний хэмжээ хэдэн см вэ?

- а. 1см      б. 1,5см      в. 0.5см      г. 2см

*II түвшин:* Загварын онцлогт нийцүүлэн 1 эмжиж, хажлага оёдог.

**Даалгавар 18.**




1. Эмжээр оёх бүдүүвч зургаас материалууд (өнгө, ар, хажлага, эмжээр)-ыг нэрлэнэ үү.

2. Нэг эмжээрийг оёх технологийг зөв дарааллалд оруулан бичнэ үү.

- ..... Эмжээрийн задгай ирмэгт хажлагыг эргүүлж индүүдэх
- ..... Материал дээр эмжээрийг суулгаж оёх
- ..... Эмжээрийн задгай ирмэгт хажлагыг барьж оёх
- ..... Эмжээрийг унагаж индүүдэх
- ..... Материал дээр наалт наах

*III түвшин:* Загварын онцлогт нийцүүлэн 2 ба 3, хашиж, хавчиж эмжиж, хажлага оёдог.

**Даалгавар 19.**



1. Хавчиж эмжих дарааллыг зураг дээр тэмдэглэж тайлбарлаж бичнэ үү.

1. ....
2. ....
3. ....
4. ....

2. Хоёр эмжих технологийн схем зургийг зурж оёдлын дарааллыг дугаарлана уу.

*IV түвшин:* Үндэсний загвартай орчин үеийн хувцсыг сонгосон загварын онцлогт нийцүүлэн эмждэг.

**Даалгавар 20.**

1. Сонгосон загварын онцлогт нийцэх эмжээрийг сонгож эмжих дарааллыг төлөвлөн бичнэ үү.

**Үнэлгээний шалгуур.** ДЗЗТ11.2.1.ҮД6.Ш6. Үндэсний загвартай орчин үеийн хувцсыг технологи үйл явц, дарааллын дагуу оёдог.

*I түвшин:* Оёдлын технологи үйл явц, дарааллыг төлөвлөдөг.

**Даалгавар 21.**

1. Сонгосон загварыг бүтээх технологийн төлөвлөлтийг хийгээрэй.

№	Материалын төлөвлөлт	Хэмжээ тоо, ширхэг	Үнэ
1	Үндсэн материал		
2	Туслах материал		
3	Наалтын материал		

2. Үндэсний загвартай орчин үеийн хувцсыг оёх технологи дарааллыг төлөвлөж бичнэ үү.

№	Технологи дараалал	Оёдлын схем зураг
1		
2		
....		

*II түвшин:* Үндэсний загвартай орчин үеийн хувцасны бүрдэл хэсгүүдийг технологи төлөвлөлтийн дагуу оёж бэлтгэдэг.

**Даалгавар 22.**

1. Хормой оёх технологийн схем зургийг зурж ажилбарыг тайлбарлаж бичнэ үү.

2. Доорх технологи ажилбарыг схем зургаар харуулна уу.

- Цахилгаан товчийг их биетэй нэгтгэж оёно.
- Оёдлыг индүүднэ.

3. Танаас оёход тавигдах шаардлагуудыг эрэмбэлэн бичнэ үү.

- .....
- .....
- .....
- .....

*III түвшин:* Үндэсний загвартай орчин үеийн хувцасны бүрдэл хэсгүүдийг технологи төлөвлөлтийн дагуу нэгтгэн оёдог.

**Даалгавар 23.**

Энгэр буюу хормойг бэлхүүсний шугамаар нэгтгэж оёх схем зургийг зурж, технологи дарааллыг бичнэ үү.

*IV түвшин:* Үндэсний загвартай орчин үеийн хувцсыг чимэглэдэг.

**Даалгавар 24.**


1. Доорх чимэглэлийн техникүүдийг ажиглаад арга технологийг тайлбарлаж бичнэ үү.




А



Б



В



Г

**ДААЛГАВРЫН ХАРИУЛТЫН ХУВИЛБАР БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ**

Сонгох болон задгай даалгаврыг дүгнэхэд сурагчдын гүйцэтгэсэн үйлдэл бүрд оноо өгөх зарчимд тулгуурласан хариултын хувилбар, оноожуулалт зайлшгүй шаардлагатай. Ялангуяа задгай хэлбэрийн даалгаврын алхам бүрийн хариултын хувилбарыг урьдчилан боловсруулсан байх шаардлагатай. Энэ нь сурагчдын ялгаатай байдлыг илрүүлэх, өөрөөр хэлбэл, сурагчдын тухайн агуулга эзэмшсэн хувийг тодорхойлох боломжийг олгодог. Хариултын хувилбарыг дараах загвараар боловсруулж болно.

*Загвар1. Хариултын хувилбар (сонгох хэлбэрийн даалгавар)*

**Даалгавар.****1. Сургалтын хөтөлбөр дэх**

Агуулга: Технологи

Дэд агуулга: Хувцасны технологи

2. **Суралцахуйн зорилт:** 11.2.1ж. Монгол үндэсний хувцсыг уламжлалт ба орчин үеийн арга технологийг хослуулан эсгэх, оёх,чимэглэх
3. **Үнэлгээний шалгуур:** ДЗЗТ11.2.1.ҮД6. Ш4. Үндэсний загвартай орчин үеийн хувцсыг технологи дарааллын дагуу эсгэдэг.
4. **Үнэлгээний зорилт:** Дизайн, техник, технологийн мэдлэг, ойлголт хэрэглээ
5. **Даалгаврын тавил:** Даавууны орцыг ..... зэргийг тооцож тодорхойлдог. Зөв хариултыг сонгоно уу.
  - A. Эдлэлийн урт, бүрдэл хэсэг
  - B. Эдлэлийн загвар, хийц, даавууны өргөн, хээ
  - C. Эрүүл ахуй болон физик шинж чанар
  - D. Эдлэлийн урт, ханцуйны урт
6. **Хариултын тайлбар:** Зөв хариулт А хувилбар

*Загвар2. Хариултын хувилбар (задгай хэлбэрийн даалгавар)*

**Даалгавар.****– Сургалтын хөтөлбөр дэх**

Агуулга: Технологи

Дэд агуулга:Хувцасны технологи

- **Суралцахуйн зорилт:** 11.2.1д. Үндэсний загвартай хувцсыг орчин үеийн эсгүүр, загварчилгааны аргаар эсгэх, загварчлах
- **Үнэлгээний шалгуур:** ДЗЗТ11.2.1 ҮД1.Ш1. Монгол дээлний суурь үлгэрийг загварчилгааны аргуудаар өөрчилж загварчилдаг.
- **Үнэлгээний зорилт:** Зохион бүтээх, гүйцэтгэх ур чадварыг үнэлэх
- **Даалгаврын тавил:** Монгол дээлний захыг өндөр тойруу захтай болгож суурь үлгэр дээр өөрчилж загварчилаарай.



- **Хариултын тайлбар:** Монгол дээлний захыг өндөр тойруу захтай болгож өөрчилж загварчилсан байдал 2 оноо
- Тойруу захны ухлаадсыг байгуулсан эсэх 1 оноо
  - Захны ухлаадасны хэв (эсгүүр) зурсан бол 0.5 оноо
  - 6-8 см доош цэг тэмдэглэж дөлгөөнөөр холбож зурсан бол 0.5 оноо
- Тойруу захны эсгүүрийг байгуулсан эсэх 1 оноо
  - Тойргийн төв болон R1, R2–ийг тооцоолж олсон бол 0.5 оноо
  - Захны өндөр уртад тохирсон эсгүүрийн байгуулалтыг хийсэн бол 0.5 оноо

## Гурав. Үнэлгээний даалгаварт шинжилгээ хийх, багшлахуйд дэмжлэг үзүүлэх арга зүй

Сурагчид тухайн ээлжит, нэгж хичээл, бүлэг сэдвээр юу ойлгож мэдсэнийг харуулах нотолгоо янз бүр байж болно. Сурагчдын хийсэн дасгал даалгавар, гүйцэтгэсэн мэдлэг, чадвар шалгах тест, гүйцэтгэсэн бие даалтын ажил, сурагчдын бүтээлүүдээс гадна төрөл бүрийн программ хангамж, техник хэрэгсэл ашиглан нотолгоо бүрдүүлэх боломжтой.

Сургалтын хөтөлбөрийн хүрээнд сурагчдын эзэмших мэдлэг, чадварыг үнэлэх, хэмжээсжүүлэхэд чиглэсэн даалгавар бүхий шалгалтын материалыг боловсруулдаг. Сурагчдын мэдлэг чадварыг хэр бодитой үнэлэх нь тухайн шалгалтын материал дахь даалгаврын чанараас шууд хамаарна. Иймд даалгаврын чанарыг тогтоох, сайжруулах зорилгоор даалгаварт шинжилгээ хийх нь ихээхэн ач холбогдолтой. Даалгаварт шинжилгээ хийхдээ даалгаврын үр дүнг нэгтгэнэ.

### ✓ Даалгаварт шинжилгээ хийх аргачлал

Сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг нэгтгэх хүснэгт дэх мэдээлэл нь тухайн агуулга, суралцахуйн үр дүнг тодорхойлох мэдээлэл, нотлох баримт юм. Өөрөөр хэлбэл тухайн нэгж агуулгын суралцахуйн үр дүн, шалгуурыг хэр олон сурагч хангасан эсэх, хангахын төлөө хичээж буй байдал, агуулгын хэрэгжилт хэр хангагдаж буй талаарх мэдээллийг агуулна.



Сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг дараах өгөгдсөн загвараар нэгтгэж болно.

#### Хүснэгт 4. Сурагчдын гүйцэтгэлийг нэгтгэх загвар

Сурагчдын нэрс	Даалгавар				Авах оноо	Авсан оноо	Гүйцэтгэл (хувимар)	Үнэлгээ	
	1	2		3					...
	Загварчилгааны аргыг таньж буй байдал 1 оноо	Монгол дээлний захыг өндөр тойруу захтай болгож өөрчилж загварчилсан байдал 2 оноо							
Тойруу захны ухладсыг байгуулсан эсэх 1 оноо		Тойруу захны эсгүүрийг байгуулах 1 оноо							
Сурагч 1	1	1	1		10	10	100	VIII	
Сурагч 2	1	0	1		10	8	80	VII	
Сурагч 3	1	0	0		10	6	60	VI	
...									
Сурагч 25	1	1	0		10	6	60	VI	
Авах оноо					250				
Авсан оноо	4	14				196			
Гүйцэтгэл %	100%	56%	52%				78%		
								VIII	
								2	
								VII	
								9	
								VI	
								5	
								V	
								6	
								IV	
								1	
								III	
								2	
								II	
								0	
								I	
								0	
								Амжилт	
								64%	
								Чанар	
								44%	

#### ДААЛГАВРЫН ГҮЙЦЭТГЭЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНГ ГАРГАХ

Дээрх даалгаврын гүйцэтгэлийн нэгтгэлээс анги нийтээр, сурагч болон даалгавар тус бүрээр шинжилгээ хийж болно.

- Анги нийтээр нь шинжилгээ хийхдээ: 25 суралцагч шалгагдсанаас 2 суралцагч 90-100% VIII түвшин, 9 суралцагч 80-89 % VII түвшин, 5 сурагч 70-79% VI түвшин гэх зэргээр ангийн сурагчдын амжилт 64%, АВ - 44% -ийг анги нийтээр нь хийж дүгнэлт гаргаж болно.
- Шалгалтын агуулгад хүнд, дундаж, хөнгөн даалгаврын хувь хэмжээг тохируулахаас тухайн үнэлгээний үр дүн ямар тархалтай байх нь хамаардаг. Үр дүн нь хэвийн (нормаль) тархалттай байх нь сурагчдыг бодитой үнэлэхэд ач холбогдолтой. Мөн даалгаврыг гүйцэтгэх хугацааг бодитой тогтоох чухал байдаг. Өөрөөр хэлбэл, сурагчдын гүйцэтгэлд тулгуурлан даалгаврын ялгах чадвар (маш сайн, сайн, дундаж, бага, сөрөг) болон хүнд хөнгөний зэргийг (хэт хөнгөн, хөнгөн, дундаж, хүнд, хэт хүнд) тогтоох, харилцан хамаарлыг шинжлэх замаар даалгаврыг сайжруулах чиглэлийг тодорхойлно. Даалгавар тус бүрээр нь шинжилгээ хийхдээ: 1-р даалгавар буюу загварчилгааны аргуудыг зөв таньж харгалзуулах даалгаврыг сурагчид 100 % гүйцэтгэсэн. 2-р даалгавар буюу суурь үлгэр дээр монгол дээлний захыг өндөр тойруу захтай болгож өөрчилж загварчлах даалгавар дээр 20 сурагчаас 11 сурагч алдаа гаргасан бол 2-р даалгавар хүндэдсэн байж болох талтай гэх мэтээр даалгавар тус бүр дээр дүгнэлт гаргаж болно.

3. Сурагч тус бүрээр шинжилгээ хийхдээ: Сурагч даалгаврыг хэрхэн гүйцэтгэснээр нь суралцахуйн үр дүнд хүрсэн эсэхийг тодорхойлж болно. Тухайлбал, 1-р даалгавар буюу загварчилгааны аргуудыг зөв таньж харгалзуулах даалгаврыг сурагчид 100 % гүйцэтгэсэн бол загварчилгааны аргуудын талаарх мэдлэг ойлголт сайн, 2-р даалгавар буюу суурь үлгэр дээр монгол дээлний захыг өндөр тойруу захтай болгож өөрчилж загварчлах даалгавар дээр 20 сурагчаас 11 сурагч алдаа гаргасан. Сурагчдын 2-р даалгаврын гүйцэтгэлд дүгнэлт хийхэд захны ухлаадсыг 6-8 см доош цэг тэмдэглэж дөлгөөнөөр холбож зурах, тойргийн төв болон R1, R2-ийг тооцоолж олохдоо ихэнх сурагч алдаа гаргасан тул энэ агуулгыг дахин тайлбарлан ойлгуулах, нэмэлт материалаар бие даан судлуулах зэргээр цаашдын хичээлийн төлөвлөлтдөө юуг анхаарч ажиллахаа багш төлөвлөнө.

**ЭХ СУРВАЛЖ:**

- Антони Ж.Нитко, Сюзан М.Брүүкхарт, 2009, “Суралцагчдын эзэмших боловсролыг үнэлэх арга зүй”
- Антони Ж.Нитко, Сюзан М, 2009 он, “Гүйцэтгэлийн үнэлгээний аргачлал”
- Антони Ж.Нитко, Сюзан М, 2009 он, “Явцын үнэлгээний аргачлал”
- Боловсролын үнэлгээний төв, 2017, Боловсролын үнэлгээ арга зүйн зөвлөмж
- Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, “Боловсролын үнэлгээ” нэр томъёоны тайлбар толь 2003 он
- Ц. Эрдэнэцог “Уран зураг бүтээлч эрэл” 2020 он
- Д. Хөхөө нар, “Багшийн ном” 2007 он
- Д. Хөхөө нар, Сурагчдын мэдлэг, чадвар, төлөвшлийг үнэлэх онол, арга зүй
- Koica, 2019, Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, сургалтын арга зүй, үнэлгээний чадавхыг бэхжүүлэх сургалтын гарын авлага
- Боловсролын хүрээлэн, 2018, “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжил, түүнд нөлөөлж буй хүчин зүйл” судалгааны тайлан
- БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, 2019, Суурь боловсролын сургалтын хөтөлбөр
- БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, 2019, Суурь боловсролын Дүрслэх урлагийн суралцахуйн удирдамж
- БСШУСЯ, 2019, Дүрслэх урлаг VIII анги
- Боловсролын хүрээлэн, 2020, Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж /Дүрслэх урлаг, дизайн технологи, дизайн зураг зүй технологи/
- БШУЯ, Боловсролын үнэлгээний төв, 2021, Суурь боловсролын Дүрслэх урлагийн хичээлийн үнэлгээний шалгуур
- <http://www.mier.mn/> Хичээлийн арга зүйн санаа
- <http://dorgio.mn/> “Азарганы ноцолдоон зургийн тухай”
- <https://mn.wikipedia.org/wiki/>
- <https://econtent.edu.mn/book>
- 2020, Cambridge assessment international education “Art and design” IGCSE
- Боловсролын үнэлгээний төв, 2017, Боловсролын үнэлгээ арга зүйн зөвлөмж
- Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, “Боловсролын үнэлгээ” нэр томъёоны тайлбар толь 2003 он
- Koica, 2019, Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, сургалтын арга зүй, үнэлгээний чадавхыг бэхжүүлэх сургалтын гарын авлага
- Боловсролын хүрээлэн, 2018, “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжил, түүнд нөлөөлж буй хүчин зүйл” судалгааны тайлан
- БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, 2019, Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр
- Боловсролын хүрээлэн, 2020, Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж / Дүрслэх урлаг, дизайн технологи, дизайн зураг зүй технологи/
- Боловсролын үнэлгээний төв, 2021, “Дүрслэх урлаг, технологи хичээл Сургалтын үр дүнг үнэлэх шалгуур хичээлийн үнэлгээний шалгуур”
- 2020, Cambridge assessment international education “Art and design” IGCSE
- БСШУСЯ, 2019, Дизайн зураг зүй, технологи X анги
- БСШУСЯ, 2019, Дизайн зураг зүй, технологи XI анги
- БСШУСЯ, 2019, Дизайн зураг зүй, технологи XII анги
- МУБИС Дүрслэх урлаг технологийн сургууль “Сорил даалгаврын сан” 2020 он
- БСШУСЯ, 2019, Дизайн технологи VIII анги
- БСШУСЯ, 2019, Дизайн зураг зүй, технологи IX анги
- МУБИС “Тест сорил даалгавар” 2020 он
- Боловсролын үнэлгээний төв, 2017, Боловсролын үнэлгээ арга зүйн зөвлөмж
- Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, “Боловсролын үнэлгээ” нэр томъёоны тайлбар толь 2003 он
- Д.Хөхөө нар, “Багшийн ном” 2007 он
- Д.Хөхөө нар, Сурагчдын мэдлэг, чадвар, төлөвшлийг үнэлэх онол, арга зүй
- БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, 2019, Суурь боловсролын сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж
- 2020, Cambridge assessment international education “Design and design” IGCSE

**ЕБС-ийн Дизайн зураг зүй, технологи хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:**

С. Отгонтуяа	Боловсролын хүрээлэнгийн ЭША
Ч. Алтанчимэг	Зөвлөх багш, 20 дугаар сургуулийн багш
С. Цолмон	Зөвлөх багш, “Шинэ эхлэл” сургуулийн багш

**Хөндлөнгийн шинжээч:**

Д.Хөхөө	МУБИС-ийн ДУТС-ийн зөвлөх багш, доктор (Ph.D), дэд профессор
---------	--

**Техникийн редактор:**

Г. Дэлгэрмаа	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, доктор (Ph.D)
Ш.Сувдмаа	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

**Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:**

С.Мөнхмаа	Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр
-----------	--------------------------------------

**Цаасны хэмжээ:** А4

**Хэвлэлийн хуудас:** 3.7 х.х



*Дэлгэрэнгүй мэдээллийг:*

[www.eec.mn](http://www.eec.mn)



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,  
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,  
Утас/Факс: 976-11 7011- 8486  
И-майл: [info@eec.mn](mailto:info@eec.mn) Вэб: [www.eec.mn](http://www.eec.mn)